

Үйлийн явцдаа суралцахуй ба багш ажлын байран дээрээ хөгжих боломж

Wusihala

Өвөр Монголын Багшийн Их Сургууль

Хураангуй

Энэхүү өгүүллийг боловсрол судлалын сүүлийн үеийн онол, үзэл баримтлал дээр үндэслэн судалсан бөгөөд багшийн өдөр тутмын үйл ажиллагааг үйлийн судалгааны аргазүйгээр судлах нь үр дүнтэй болох асуудлыг хөндсөн болно. Мэдээлэл харилцааны технологи өндөр хөгжсөн эдүгээ үед багшлахуй, суралцахуйн онолд үндэслэн үйлийн судалгааны аргазүйг хэрэгжүүлэх, хүмүүний үнэт зүйлд тулгуурлан, хувь хүний онцлогийг харгалзан багш ажлын байран дээрээ хөгжих сургалтыг зохион байгуулах нь чухал юм. *“Судалгаа” гэдэг нь үндсэндээ шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг бусадтай хуваалцан түгээн дэлгэрүүлэх үйл явц хэмээн тодорхойлсоноос үзвэл*, судалгаа нь багшлах ажлын үр дүнд, багшийн хөгжилд ямар чухал болох нь тодорхой. Багшийн мэдлэг чадвар нь сурах үйлийн чанарыг сайжруулахад хамгийн гол хүчин зүйл нь болж байна. Тиймээс багш өдөр тутмын сургуулийн амьдрал дахь асуудлыг олж харж, шийдвэрлэх арга замыг багшлангаа судлах, судлангаа багшлах боловсролын чанар үр дүнг сайжруулах боломж хэр байгааг тогтоох нь бидийн судлан буй өгүүллийн гол зорилго болно.

Түлхүүр үг

Үйлийн судалгаа, багшийн хөгжил, ажлын байран дээрээ хөгжих, багшлахуй, суралцахуй

Удиртгал

Боловсролын үйлчилгээний чанарыг хэрхэн үр ашигтай, хүртээмжтэйгээр нэмэгдүүлэх вэ? боловсролын салбарт хүртээмжийг хэрхэн өсгөх вэ? зэрэг асуудал нь зөвхөн багш нар төдийгүй судлаачид, эрдэм мэдлэгийг эрхэмлэгч хүн бүрийн санаа тавих эрхэм зүйл болж байна. Багш нарын мэдлэг боловсрол, мэргэжил, заах арга зүй, ур чадварыг төвлөрсөн сургалтаар дээшлүүлдэг байсан уламжлалт арга нэгэнт үеэ өнгөрөөж, төдийлөн үр дүнтэй бус гэдэг нь амьдралаар нотлогдсоор байна. Өөрөөр хэлбэл, багш хүн гадны ямар нэг шахалт шаардлагаар, тодорхой хөтөлбөрийн хүрээнд мэргэжлээ дээшлүүлээд хязгаарлагдах бус, өөрийн үйл ажиллагаандаа бүтээлч эргэцүүлэл хийж, шүүмжлэлтэй хандан, ажлын байран дээрээ мэдлэг, ур чадвараа тасралтгүй байнга дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өнөөдөр багш нар өөрийгөө хөгжүүлэх талаар эрэл хайлт хийж байгаа боловч тэр нь голдуу «хуулбарлах» сэтгэлгээнд хөтлөгдсөн, бусдаас суралцах, олон улсын туршлага практикаас л бүхнийг мэдэж, хөгжиж болно гэсэн хуучин сэтгэлгээнээсээ төдийлөн салж чадахгүй байна. Багш хүн ажлын байран дээрээ, сурган хүмүүжүүлэх үйлийнхээ явцад хөгждөг тухай үзэл санаа, туршлага сургамжийг ухамсартайгаар хүлээн авч ажиллах нь хамгийн энгийн бөгөөд

хамгийн чухал асуудал байна. Энэ нь багшаас сургалтын үр дүнгээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, сургалтын практикийг баяжуулахад ихээхэн тус дэм болох болно. Багш хүн нийгмийн хөгждийн чиг хандлагыг урьдчилан харж, сургалт хүмүүжлийн үйл ажилагаагаа хэтийн төлөвтэй хоорондын уялдаа холбоотойгоор явуулж, үр дүнд хүрч байх ёстой бөгөөд багшийн хөгжлийн үйл явц, үр дүн нь багш бүрийн хамтын бүтээлч үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Тийм учраас багш бүр судалгаа хийх аргазүйг эзэмшиж, тогмолжуулж, чанаржуулах нь (Буянжаргал. Л, 2015, х-153) шинэ үеийн багшийн чадамж болно. Сүүлийн үед багш нарын идэвх оролцоо нэмэгдэж, багшийн талаар хэрэгжүүлж байгаа гадаадын хөтөлбөр, төслүүдэд хамрагдан өөрийн хөгжлийг хангах, чадвартай багш болох талаар сэтгэлгээ нь өөрчлөгдөн байгаа нь сайшаалтай.

Багш нар үйлийн буюу ажиллах явцдаа мэдлэг мэргэжил, ур чадвараа тасралтгүй байнга дээшлүүлэхэд үйлийн судалгаа ихээхэн үүрэгтэй болохыг судлаачид онцлон тэмдэглэсээр байна. Иймээс бид хүмүүний оршин амьдрах зайлшгүй нөхцлөө бий болгох зорилгоор мөн чанар болох бодит ахуйтайгаа (Жадамбаа.Б, 2010, х-35) боловсролын салбарт өргөн хүрээтэй хэрэглэж, туршлага хуримтлуулж, үр дүнд хүрч байгаа

“Үйлийн судалгаа”-ны талаар товч өгүүлэхийг зорьсон юм.

Үйлийн явцад суралцахуй нь яагаад чухал вэ?

Ертөнцийг нэг талаас, хамаг бүгдийн салах аргагүйгээр амьсан сүлбэлдсэн нэг амь буюу нэг амин нэгдэл (Б.Жадамбаа, 2010), нөгөө талаас ертөнц нь нэг /нэг бодгаль/ хийгээд бодгаль/* бодгаль нэг*2 (Б.Жадамбаа, 2013) хэмээн оюутны мэлмий нь нээгдэх үеэсээ л ухаарч, ертөнцийг нэвч таньсан ард түмний нэг бол монголчууд билээ хэмээн академич Б.Жадамбаа судалгааны өгүүлэлдээ үйл судлалын мөн чанарыг нэгэнтээ тодорхойлон хэлсэн нь бий. (Б.Жадамбаа, 2013. х-7) Тэгвэл барууны судлаачдын нэг болох АНУ-ын судлаач Жефри Миллс өөрийн судалгааны бүтээлдээ дурдахдаа “Үйлийн судалгаа гэдэг нь багш болон сургалтад оролцогчид мэдээлэл цуглуулан сургуулийн үйл ажиллагаанд оролцох, багшлах, суралцагчид нь хэрхэн амжилттай сурахыг дэс дараалуулан сайжруулах системтэй шинжлэн судлахуй юм” (Е.Миллс, 2007, х-11) хэмээжээ.

Багш хүн өдөрт маш олон төрлийн үйл ажиллагааг явуулж байдаг. Тухайлбал хичээлээ заах, ангитай ажиллах, хуралд оролцох, сурагчдыг үнэлж дүгнэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, анги тохижуулах, жижүүр багшаар ажиллах, дэвтэр засах гэх мэт олон ажлыг амжуулж ажилладаг. Энэ олон төрлийн ажлыг бүгдийг нь чанартай сайн хийх хэрэгтэй ч ажлын ачаалал ихэдсэнээс эдгээр ажлыг бүгдийг нь чанарын өндөр түвшинд зохион байгуулах шаардлагатай ч нэгэн зэрэг сайжруулах боломж хязгаарлагдмал юм. Нөгөө талаас үйлийн явцад суралцахуй нь анги танхим дахь практикийг өөрчилж, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмждэг бүтээлч үйл ажиллагаа тул үүнд суралцсанаар дээрх бүхнийг чанартай зохион байгуулах боломжтой юм.

Үйлийн явцад суралцахуйн давуу талууд нь:

- Багш өөрөө үйлийн эзэн байдаг.
- Багшлах үйл ажиллагааг чанаржуулдаг.
- Багш сурагчдыг хөгжүүлдэг.
- Практикийн тухай мэдлэг бүтээдэг.
- Бүтээмж өндөртэй.

Үйлийн явцад суралцахуйг хэрэгжүүлэхэд юуг анхаарах вэ?

Үйл судлалыг боловсролын судалгааны аль ч хүрээнд ашиглах бололцоотойг олон эрдэмтэд зөвлөж байна. (Пүрэвдорж, 2013) Үүнд, багшлахуйн менежмент, хяналтын асуудлыг сайжруулах, багшлахуйн хийгээд сурахуйн стратегийг судлах, багшлахуйн мэргэжлийн хөгжлийг судлах, боловсронгуй болгох, багшлахуйн аргазүйг хөгжүүлэх, сурагчдын сурах арга барилыг тодорхойлж хөгжүүлэх (D.

Odgerel, 2017. р-44) зэрэг олон асуудлыг судлах боломжтой юм.

Багш хүнд багшлах үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийж тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлээ илрүүлж түүнээсээ сайжруулах үйлээ зөв сонгох нь маш чухал. Үйлээ зөв таньж сонгоод сайжруулахын тулд дараах үе шатны дагуу ажиллахыг үйл судлаачид зөвлөдөг.

- Асуудал тодруулах
- Үйл төлөвлөх
- Үйлдэх
- Үйлд ажиглалт хийх
- Ажиглалтанд эргэцүүлэл хийх
- Үзэл баримтжуулах
- Үйл шинээр төлөвлөх

Асуудал тодруулах. Багшлахад нэн тулгамдаж байгаа асуудлаа олж харан, бусдын санаа бодлыг сонсож харилцан ярилцсаны үндсэн дээр асуудлаа томъёолно.

Үйл төлөвлөх. Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой хугацаанд, юуг?, яаж? хийх, ямар мэдээ баримт цуглуулах, түүнд хэрхэн боловсруулалт хийх, хэнтэй хамтарч ажиллах, ямар ном материал судлах, зэргээ сар, улирал, жилээр хуваарилан тухайн нөхцөл байдалдаа тохируулан үндэслэлтэй төлөвлөнө.

Үйлдэх. Ном эх материал судлах, эмпирик арга болох ярилцлага, ажиглалт, асуулга, туршилт зэргийн тусламжтайгаар судалгааны баримт цуглуулах, цуглуулсан баримтанд боловсруулалт хийх гэх мэт тухайн асуудлаа тал бүрээс нь шинжилж таних, улмаар сайжруулах туршилтыг бусад багш нартай хамтран гүйцэтгэнэ.

Үйлд ажиглалт хийх. Өөрийн болон нөхдийнхөө хийсэн үйл үйлдлийг ажиглаж онцлог зүйл, давуу болон сул тал ач холбогдол, холбоо хамаарал, үр нөлөө зэргийг нь нарийвчлан гаргаж туршилтын явц үр дүнд задлан шинжилгээ хийж боловсруулна.

Ажиглалтанд эргэцүүлэл хийх. Хийсэн ажлынхаа үр дүн холбоо хамаарал, шалтгаалсан зүйл, ололт болон дутагдалтай зүйлс, сайжруулах зүйл зэрэгт тал бүрээс шинжилнэ. Би юуг яаж хийж байна? Яагаад ингэж хийж байна? Үүнийг яаж засч сайжруулах вэ? Надад ямар ололттой болон дутагдалтай тал байна вэ? Бусад багш нартайгаа хэрхэн хамтан ажиллах вэ? зэрэг асуултуудын дагуу шинжилж эргэцүүлнэ.

Үзэл баримтжуулах. Хийсэн ажлынхаа явц, үр дүнг эрдэмтдийн онол үзэл баримтлалтай холбох, өөрийн санаа бодлоо илэрхийлэх байдлаар онолын үндэслэлийг гаргана.

Үйл шинээр төлөвлөх. Хэрэгжүүлсэн ажлынхаа явц, үр дүнд тулгуурлан цаашид улам боловсронгуй болгох сайжруулахын тулд Юуг?

Яаж? хийх талаар дахин төлөвлөх бөгөөд эхний сонгосон үйл дахин үргэлжлэх нь зүйтэй.

Иймээс үйлийн явцдаа суралцахуйг арга билгийн нэгдэлд нь билиг болох “онол” /практик-онол/ - практик талаас авч үзэхийн жишээ нь түүний мөн чанар талын томъёолол буюу ажил хийж ХҮН болдог ард давж ХҮЛЭГ болдог “(Б. Жадамбаа, 2010, х-72) хэмээх монгол ардын уламжлалт соёлтой холбож, өөрийн багшлах үйлдээ тусгах нь амжилттай хэрэгжүүлэхийн үндэс хэмээн үзэж байна.

Үйлийн явцад суралцахуйг хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тохиолддог вэ?

Үйлээ зөв таньж сонгохгүй байх. Багш нар үйлээ сонгохдоо үйл, үйл ажиллагааг ялгахгүй маш том үйл ажиллагаа сонгож түүнийг судалж гүйцэхгүй хэт өрөнхий судалгаа хийж алдаж байсан. Сонгох үйл маш тодорхой, жижиг байх тусмаа түүнийг тал бүрээс нь судлан илүү их таньж сайжруулах боломжтой байдаг.

Төлөвлөсөн ажлаа хугацаанд амжуулахгүй байх. Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ажлаа хэрэгжүүлэхийн тулд хувийн зохион байгуулалтаа сайжруулж, цагийн хуваарь нарийвчлан гаргаж түүнээ мөрдөхдөө цагийг үр бүтээлтэй ашиглан ажиллах нь чухал. Хамтран ажиллаж буй удирдлага, хамт олон, багш нар ойлгож дэмжихгүйгээс сургуулийн захиргаанаас зохион байгуулж буй цаг үеийн ажилд дайчлагддаг.

Хуучин арга барил сэтгэлгээнээс салж чадахгүй байх. Шүүмжлэлт, бүтээлч, шинэлэг, латераль сэтгэлгээгээр аливаа асуудалд хандаж Яагаад? ийм байх Яаж? боловсронгуй болгож сайжруулах талаар эрэл хайгуул хийж ажиллах хэрэгтэй байна.

Сургах нь бүхэлдээ практик асуудал. Сургах нь үйл. Сургах нь практик. Сургах практик гэдэг нь судалгаа, шинжилгээ явуулж цуглуулсан материал, баримтдаа бүтээлч эргэцүүлэл хийж, гарсан шинэ санаа, үр дүнгээ практикт хэрэгжүүлэх үйлээ нэг бүрчлэн төлөвлөж, гүйцэтгэх нарийн цогц үйл явц юм. Гэвч багш нар зөвхөн тухайн хичээлээр юу заах вэ? яаж заах вэ? сурагчид хэрхэн хүлээн авч байна вэ? гэдэгт л ач холбогдол өгдөг. Тиймээс тухайн ангид ороод хичээл заах нь тухайн багшийн хувийн асуудал мэт болсон агаад бусдаасаа туршлага судлах, тэдний хичээлд суун зөвлөн туслах үйл ажиллагаа огт байхгүй байна хэмээн хэлж болохоор байна. Нийгэм соёлын талаас нь сурах үйл нөхцөлддөг талаас нь харвал сургах үйл нь зөвхөн хувь хүний хэрэг биш хамтын үйл юм.

Гэвч нэг талаар багш нар өөрсдийн болон бусад багш нарын хичээлийг системтэйгээр

ажиглаж түүнийгээ сургалтандаа ашиглах цаг зав хомс байдагтай холбоотой байж болох юм. Тиймээс өнөөгийн уламжлалт сургалт нь багш нарт сургалтын хөтөлбөрийн дамжуулагч идэвхгүй байдлаар ажиллахад хүргэж байна. Энэхүү асуудлыг тайлбарлахын тулд өөрийн амьдралд тохиолдсон нэгэн жишээг сонирхуулъя. Би сургуулиа төгсөөд их сургуульдаа багшаар ажиллахаар үлдэв. Шинэхэн багш тул шинэлэг байдлаар хичээлээ заахыг хичээнэ. Гэтэл анхны хичээлээс эхлээд олон хүндрэлтэй асуудлуудтай тулгарсан агаад надад багшлах ур чадвар дутагдаж байгаа нь мэдрэгдэж байв. Би ч багш нараасаа асуух гэхээр жаахан нэрэлхүү зан дийлээд асууж чаддаггүй байв. Тиймээс дээрх асуудлаа шийдэхийн тулд чимээгүйхэн надад тус болчихоор номуудыг уншиж эхлэсэн боловч төдийлөн ахиц гарахгүй л байв. Ингээд нэг өдөр зориг гарган тэнхмийнхээ ахмад багшид хандан бэрхшээлээ ярилаа. Гэтэл багш миний байдлыг аль хэдийн анзаарснаа хэлээд энэ бол зөвхөн ном уншаад сурдаг асуудал бишээ, чамд практик хэрэгтэй миний хичээлд суу намайг ажигла, анализ хий, би ч чиний хичээлд суун заавар зөвлөгөө өгье, тэгээд өөртөө хэрэгтэй гэсэн зүйлээ авах гээхийн ухаанаар тунгаана биз хэмээн хэлсэн юм. Багш маань миний хичээлд уйгагүй суун зөвлөгөө өгч хамтран ажилласнаар би ч өмнө нь судалж байсан сургалтын аргуудаасаа хичээлдээ туршин хэрэглэж, багш сурагчдын харилцаатай холбоотой олон зөвлөгөөг авч ажилласнаар хүндрэлтэй асуудлаа даван туулж чадсан юм. Тиймээс энэ цагаас хойш багш нарын хамтын ажиллагаа, харилцаа болон хамтын үйлчлэл нь ямар чухал ач холбогдолтой болохыг сайтар ойлгож авсан юм.

Үүнээс гадна жинхэнэ мэргэжлийн багш хүн хичээлийг ямар ангид ямар арга зүйгээр заавал илүү үр дүнтэй байх вэ? гэдэг талаар байнга эрэлхийлж, өөрийн мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж байхыг эрмэлздэг бүтээлч нэгэн байх ёстой тул үйлийн судалгааг сонирхон судлах болж, судалгааны ажил бичиж эхэлсэн билээ. Үйлийн судалгаа нь практикийг бодит байдалд нь системтэй судалснаар түүнийг өөрчлөн шинэчилж чадахуйц судалгааны арга гэсэн үндсэн агуулгатайгаар багшийн судалгаа, практик ажилтны судалгаа, оролцогчдын судалгаа гэх мэт олон янзын нэрээр хөгжиж иржээ. Тиймээс л бид ажлын байран дээрээ эсвэл өөрийгөө хөгжүүлэхдээ өөрийгөө гурван цагийн холбоонд зөв оношлохоос эхлэх нь шинжлэх ухааны (Б.Энхтүвшин, 2016. х-5) үйлийн судалгааны гол шаардлага болно гэдгийг ахмад багшаасаа зөвлөгөө авсан өөрийн туршлагаасаа

сайтар ойлгож авсан билээ.

Үйлийн судалгааны тодорхойлолт
Бид үйлийн судалгааг дараах байдлаар тодорхойлж байна.

- Үйлийн судалгаа нь практик үйлээ өөрчлөх замаар судалгааны арга зүйг эзэмшин эргэцүүлэл хийснээр хөгжих, багшаас өөрийн практикийн талаарх үзэл бодол таамаглалыг практикт шалган туршихыг шаарддаг
- Үйлийн судалгаа нь бусад багш нарынхаа хамт ажиглалт хийж, ажил хэрэгчээр нээлттэй ярилцаж өөрсдийн мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэн хамтын ажиллагаанд тулгуурласан үйл юм
- Үйлийн судалгаа нь асуудлыг тодруулах, үйлийг төлөвлөх, өөрийн үйл ажиллагаандаа ажиглалт хийн эргэцүүлэн хянах буюу үйлийг шинээр төлөвлөх зэргээр тасралтгүй үргэлжлэх үйл юм.

Ингэснээр тухайн багш үйлийн явцдаа үйлээ шинэчлэн шинэ мэдлэг бүтээдэг. Эндээс бид үйлийн судалгаа гэж чухам юу болох, үйлийн судалгааны арга, үе шат, онцлогийн талаар авч үзье.

Өнгөрсөн зууны дунд үеэс Америкийн иргэн Курт Левин тухайн нийгмийнхээ нэгэн чухал асуудлыг судлан шийдвэрлэх зорилгоор үйлийн судалгааг анх хийж байжээ. Үйлийн судалгааны арганы үүнээс хойш бусад салбаруудад ялангуяа боловсролын салбарт өргөн хэрэглэгдэх болсон байна. Улмаар 1970-1990-ээд оны үед дэлхийн олон орны боловсролын салбарт үйлийн судалгаа мэдэгдэхүйц нөлөөтэй болсон байна. Боловсролын салбар дахь үйлийн судалгааны хэд хэдэн гол шинжийг Австралийн судлаач Кемис, Таггарт нар дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Үйлийн судалгаа нь практикийг өөрчлөн шинэчлэх, *хөгжүүлэх гол зорилготой*.
2. Үйлийн судалгаа бол асуудлыг тодруулах, үйлийг төлөвлөх, үйлд ажиглалт хийх, эргэцүүлэн хянах буюу үйлийг шинээр төлөвлөх гэсэн үе шатаар өөрийгөө хөгжүүлэх үйл явцаас бүрддэг.
3. Үйлийн судалгаа бол оролцогч төвтэй.
4. Үйлийн судалгаанд хамтын ажиллагаа чухал үүрэгтэй.
5. Үйлийн судалгаа нь өөрийн практик үйлийг онолжуулж, практикийн тухай шинэ мэдлэг бүтээдэг.
6. Үйлийн судалгаа нь багшаас өөрийн практикийн талаарх үзэл бодол, таамаглалыг амьдрал практикт шалган

туршихыг шаарддаг.

7. Үйлийн судалгааг ажиглалт, сурган хүмүүжүүлэх тэмдэглэл, өдрийн тэмдэглэл, бүтээлийн сан, ярилцлага гэх мэт баримт, мэдээллийг цуглуулах олон арга хэрэгсэлийн тусламжтайгаар хийдэг.
8. Нэгэнт сонгож авсан үйлийн судалгаа нь ямагт тодорхой тооны үйл ба түүнийг хийх оролцогчдыг сонгох төлөвлөхөөс эхэлдэг.
9. Үйлийн судалгаа нь тодорхой нэг практикийг тухайн нийгэм, түүхийн хүрээнд нь авч судлах үүрэгтэй гэх мэтээр тодорхойлжээ.

Эндээс үйл ажиллагааг судалгаатай хослуулсан хандлага нь судлаачид хийгээд багш нар түүнчлэн боловсролын хамтлагийн анхаарлыг зүй ёсоор татсан байна.

Хэрэв багш, судлаач та бүхэн чухам ямар арга зүй үр дүнтэй байна вэ? Яагаад? Ямар учраас ийм сайн үр өгөөжтэй байгааг мэдэхийг хүсч байгаа бол чанарын судалгааны нэг гол арга болох «Үйлийн судалгаа»-ны арга зүйд суралцахыг танд санал болгож байна. Сурах, сургах цогц үйл ажиллагааг хэрхэн нягт боловсронгуй болгох вэ? мэдлэг, практик хоёр хоорондоо ямар холбоотой байдгийг судалж, танин мэдэхийн тулд мөн л «Үйлийн судалгаа» хийх шаардлага гарч байна.

Үйлийн судалгааны загвар: Өдөр тутмын үйл ажиллагаа, амьдралд тус болох практик мэдлэг бүтээх, практик мэдлэгийн үндсэн дээр хүний хүчин зүйлийн хөгжлийг сайжруулах (багш хөгжих), мэдлэг бүтээх шинэ чадвар, аргад суралцахад оршдог. Эндээс үзвэл практикаас мэдлэгийг бүтээж, өөрийгөө хөгжүүлсе, шинэ чадвар эзэмшье гэвэл үйлийн судалгаанд суралцах нь багш бидэнд чухлаар тавигдаж байгааг анзаарч буй за. Үйлийн судалгаа нь танхимын практикийг сайжруулах болон багшийн мэргэжлийн хөгжилд дэм үзүүлэх утгаараа багшид ойр байдаг. Тиймээс үйлийн судалгаа нь багшийн ажил үйл дээр түшиглэдгийнхээ хувьд багшийн эрэлт хайлт, бүтээлч эргэцүүллийг хөгжүүлдэг. Үйлийн судалгааны хамгийн гол онцлог нь багш нар хийж байгаа үйлийнхээ талаар системтэй эрэл хайгуул хийж, шинэ санаа арга туршлагыг хуримтлуулдагт оршино. Чухамдаа энэ нь шинэ мэдлэгийг бий болгож байгаа юм. Үүний тулд өөрсдийнхөө үйлийг системтэйгээр сайжруулах оролдлого хийх, өөрсдөө системтэй суралцах, шинэ үйл нь хэрхэн явагдаж байгаад эргэцүүлэл хийх нь үйлийн судалгаанд чухал нөлөө үзүүлдэг болохыг практик нотолж байна.


Энэ утгаараа үйлийн явцад суралцах нь ажлын үр дүнг дээшлүүлэх, багшийг хөгжүүлэх

хамгийн дөт зам болох нь тодорхой байна. Одоо багш танд үйлийн судалгааг хэрхэн хийх талаар товч мэдээлэл хүргэж байна.

Үйлийн судалгаа буюу үйлийн явцад суралцах арга барилыг туршиж эзэмшихийн тулд үйл болон үйлийн судалгааны цикл (орчил)-ийг сайн мэдэж, үйл ажиллагаандаа баримтлах нь чухал гэдгийг анзаарахгүй өнгөрч болохгүй. Профессор Ж.Балтзерсен “Үйл гэж юуг хэлээд байгааг тодруулъя. Учир нь үүнийг үйл ажиллагаатай хольж хутгах тохиолдол нэлээд байдаг» гээд “*Үйл гэдэг нь танхимын сургалтын маш тодорхой зорилго чиглэлтэй төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэлж байгаа юм. Үйл явцын туршид системтэй судалсан үйлээс тодорхой үр дүн гардаг*» (“Мэдээлэл-2007”) хэмээсэн байна. Тэгэхээр та судлах үйлийнхээ талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй юм.

Бүтээгчийг бүтээгч боловсролын бүх үе шатанд ажиглах, эргэцүүлэл хийх зэрэг үйлийн судалгааны цикл явагдана. (Enkhmaa A, 2017.p-55)

Үйлийн судалгааны төлөвлөлтийн цикл (орчил):



1. Асуудлыг сонгох, тодорхойлох
2. (Асуудлаа оновчтой тодорхойлох нь судалгааны цаашдын үр дүнд ихээхэн ач холбогдолтой бөгөөд танхимын практиктай буюу сургуулийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой туршлага, бэрхшээлүүд байж болох юм.) Хүчин зүйлсийг тодорхойлох: Энэхүү алхамд судалх асуудалд нөлөөлөх бүхий хүчин зүйлсийг жагсааж бичээд хамгийн чухал гэж үзэж байгаа хүчин зүйлсийг сонгож авна.
3. Үйлийн төлөвлөлт (Тодорхой асуудлаар шийдвэрлэх үйлээ төлөвлөн жагсаах)
4. Үйл (Шинэ арга зам, чиг хандлага, сонгосон асуудлаа турших)
5. Үйлийг ажиглан судлах (Үйлийн явцад ажиглалт, тэмдэглэл хөтлөх, өдрийн тэмдэглэл хийх)
6. Ажиглалтандаа шинжилгээ хийж эргэцүүлэх (Юу өөрчлөгдсөн, ямар үр дүнд хүрсэн, цаашид яавал зохих)
7. Шинэ санаа төрөх (Түүнийгээ онолжуулах, үзэл баримтжуулах)
8. Сайжруулсан шинэ үйл (Үйлийн судалгаа тасралтгүй үргэлжлэх тул ололт, дутагдлаа дүгнээд, дараагийн сайжруулсан шинэ үйлийг төлөвлөх)

Эрдэмтэн судлаачдын бүтээл туурвилаас өнгөцхөн боловч ажиглахад үйлийн судалгаа нь үйл хийгээд судалгааны нэгдэл бөгөөд бүтээлч эргэцүүлэлийн тусламжтайгаар өөрийнхөө практик үйл ажиллагааг сайжруулдаг цогцолбор ажиллагаа гэдэг нь харагдана. (Оюунбат.Н, 2016, х-23)

Үйлийн судалгаа явуулах энэхүү циклийг баримтлах нь их ач холбогдолтой бөгөөд үе шат бүрийг нарийн төлөвлөж гүйцэтгэх нь үйлийн судалгааг үр дүнд хүргэх гол хөшүүрэг болохын дээр амжилтанд хүргэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Үйлийн судалгааны үзэл санааг монгол ардын зүйр үгээр илэрхийлбэл:

Үйлийн судалгааны үйл явц	Монгол ардын зүйр цэцэн үгс
Асуудлыг тодруулах	Аргыг нь олбол, бэрхийг давна Амты нь авбал шимтий нь, атгы нь авбал чимхий нь
Тухайн асуудалд чиглэгдсэн үйлийг төлөвлөх	Бодохгүй унших нь захлахгүй залгихтай адил Ажил хийдэггүй хүн, алдаа гаргадаггүй
Үйл: шинэ арга зам, хандлагыг турших	Хүн хүний хүчинд, загас усны хүчинд Дэм дэмэндээ, дээс эрчиндээ
Үйлийг ажиглах	Гэмээ мэдсэн хүн, гэгээн ухаантай Хүний гараас тос долоосноос, өөрийн гараас ус долоо
Ажиглалтанд эргэцүүлэл хийх	Олны дотор үгээ шинж Ганцаар явахад сэтгэлээ шинж
Үзэл баримтжуулах онолжуулах	Юманд учир, суманд гичир Алсыг харвал аминд тустай, холыг харвал хожим тустай
Сайжруулсан шинэ үйл	Эхэлбэл дуусгах хэрэгтэй Эрвэл олох хэрэгтэй Эрлийг сургаар олдог Эрдмийг хичээлээр олдог

Үйлийн судалгааны явцад та өөрийн хуримтлуулсан туршлага болох үйл ажиллагааны явцыг бүхэлд нь үнэлж дүгнэх нь чухал. Үйлийн судалгааны гол онцлог нь багш өөрт тохиолдож буй бодит бэрхшээл, түүнээс гарах арга замыг өөрийн чадвар, боломж, үйл ажиллагааны орчинд тохируулан сонгон авснаар эцсийн үр дүн нь багшийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байх учиртай. Үйлийн судалгааны аргууд:

Үйлийн судалгаанд маш олон аргууд хэрэглэгддэг боловч чанарын аргууд болох ажиглалт, ярилцлага, түшицбүлгийн хэлэлцүүлэг, өдрийн тэмдэглэл, сурган хүмүүжүүлэх тэмдэглэл зэрэг аргууд зонхилдог. Уламжлалт судалгаанд судалгааны төслийг хэрэгжүүлэх болон анхны боловсруулалт хийж эхлэхийн өмнө мэдээ баримт цуглуулж, арга хэрэгслээ тодруулж сонгосон байдаг. Үйлийн судалгааны төлөвлөлт нь үйл болон судалгаа, тэдгээрийн нэгдлийг агуулсан байдаг ба энэ нь уламжлалт судалгааны төлөвлөлтөөс эрс ялгаатай юм. Жишээ нь: Үйлийн судалгаа нь харилцан ярианаас эхэлдэг. Тодруулбал, оролцогч багш нарын болон бусад хүмүүсийн дунд судлахаар сонгосон бэрхшээлтэй асуудлын тухай, ангид бий болсон шинэ үйлийн талаар судлаач буюу оролцогч багш нарын дунд харилцан яриа өрнүүлсэнээр эхэлдэг.

Үйлийн явцад суралцахуйн үйлээс үрд буюу санаанд шилжих хэсгийг идэвхгүй буюу бүтээлч бус, санаа буюу үрээс үйлд шилжих хэсгийг идэвхтэй буюу бүтээлч хэмээн тус тус нэрлэж болно. Өөрөөр хэлбэл, үйлийн буюу ажиллах явцдаа суралцахуй нь идэвхгүй буюу бүтээлч бус болон идэвхтэй буюу бүтээлч хэсгүүдийн нэгдэл байдаг байна. Багшийн идэвхгүй бүтээлч бус үйл нь зөвхөн ажиглах дээр түшиглэн санаа бий болоод зогсдог бол, идэвхтэй бүтээлч үйл нь ажигласнаа шинжлэн санаанаас өөр үйл бий болгон тасралтгүй ажил үйл өрнүүлдэг байна. Багшийн өдөр тутмын ажил, хөдөлмөр нь өөрөө бүтээлч бус ба бүтээлч хэсгүүдийн нэгдэл байдаг. Тэндээс л бүтээлч ба бүтээлч бус багш хэмээх нэр томъёо үүсжээ. Бүтээлч багш ба үйлийн явцад сурах арга зүйд сурсан багш хоёрт ижил олон шинжүүд байдаг боловч эдгээр нь ялгаатай ухагдахуунууд юм. Үйлийн явцад суралцахуйд сурсан багш нь өөрийнхөө үйлийг байнга тасралтгүй, системтэйгээр шинжилдэг, бусадтай нягт хамтран санаа бодлоо хуваалцан ажилладаг, бусдыг дагуулан сургадаг, бусдад тусалдаг, судалгааны бүтээл бэлтгэн гаргадаг гэх мэтээрээ бүтээлч багшаас ялгаатай.

Түүнээс гадна үйлийг судлаач баримтаа судалгааны “ажиглан эрэгцүүлэхүй” гэсэн нэг л аргаар цуглуулдаг. Харин тэрхүү үйлийн

ажиглан эрэгцүүлэхүйн аргын хэрэглэл нь “үйл” талаасаа бол ажиглахуй, ярилцахуй, тэмдэглэл хөтлөхүй, газар дээр нь ажиллахуй, асуухуй, баримт материалыг задлан шинжлэхүй, аудио ба видео бичлэг үзэхүй, ном зохиол судлахуй, зүйл талаасаа бол ажиглалт, ярилцлага, бичвэр буюу тэмдэглэл, кейс асуулга, баримт материал, асуулга, видео, болон аудио бичлэг, ном зохиол зэрэг болно. (Б.Жадамбаа, 2016. х-103) Өөрөөр хэлбэл, үйлийн судалгааны баримтыг цуглуулахад судалгааны баримтыг цуглуулахад судалгааны бүхий л аргууд хэрэглэгддэг гэж хэлж болно. (Б.Жадамбаа, Ц.Чимэдлхам, 2000. х-25)

Үйлийн судалгаа нь практикийн оролцоотойгоор цоо шинэ үйлийг төлөвлөн эхлүүлдэг онцлогтой. Иймээс үйлийн судалгаа бол мэдлэгийг бүтээгч чухал зам; практикийн тухай онолыг бүтээх зам; практик дахь онолыг бүтээх чухал зам; практикийг хөгжүүлэх хэлбэр юм. Монголчуудын өөрсдийн агуу их түүхээ бүтээсэн хам хүрээнд хийгээд бодит үйл явцад түшиглэсэн эмпирик прагматик үйлийн судалгаа болох “үйлийн явцдаа суралцахуй” хийгээд хүмүүнээр ХҮН хийх арга ухаан бол ТХБ- ыг сургах/сургахуйн үндсэн арга технологи юм. (Б.Жадамбаа, 2015. х-113)

Дүгнэлт

Уламжлалт судалгаагаар таамаглал дэвшүүлж, тэдгээрийг туршин онолыг бүтээдэг байсан бол үйлийн судалгаа нь асуудлыг шийдвэрлэж, өөрчлөлт авчирдагаараа онцлог юм. Иймээс үйлийн судалгаа нь өөрөө маш бүтээлч үйл ажиллагаа бөгөөд түүний ашиг шимийг багш, суралцагч хоёр хоёулаа хүртэх боломжтой. Судалгаа хийх явцад ямар ч хүн хүрээлэн буй бодит орчин, өөрийн мэдлэг, чадвар, туршлагын талаарх ойлголтоо гүнзгийрүүлснээр хөгжлийнхөө тувшинд үнэлгээ дүгнэлт өгч, хэрэгцээ шаардлагаа сайтар мэддэг болно. Багшийн хувьд хийсэн судалгааны үр дүн нь өөрийн сурган хүмүүжүүлэх арга ажиллагааг сайжруулах, суралцагчийн хувьд илүү сайн сурч хөгжих боломжуудыг тус тус нээж өгдөг.

Юуны өмнө Би хөгжих хэрэгтэй юу?, Надад хөгжих ямар хэрэгцээ байна вэ?, Тэрхүү хөгжих хэрэгцээгээ хэрхэн хангах вэ?, Ер нь би хэрхэн хөгждөг вэ?, Яаж хөгжих нь өөрийн тань амьдрал, ажил үйлсэд хамгийн их ач тустай байна вэ? гэсэн асуултуудыг бүтээлчээр эргэцүүлэх буюу ярилцах замаар «үйлийн буюу ажиллах явцдаа суралцахуй» үнэхээр чухал болохыг ойлгож ухамсарлах,

Яаж үйлийн явцад сурах вэ? гэдгийг

бүтээлчээр эргэцүүлэн, туршиж түүний талаар өөрийн гэсэн санаа буюу баримжаатай, загвартай болох, өөрийн бүтээн буй болгосон үйлийн баримжаа, загвараа сайжруулах үйлийн явц, үр дүнг ажиглах, шинжлэх, эргэцүүлэх, байнга оновчлох, өөрийн гэсэн бодолтой, санаатай болох, түүнийгээ бусад багш нартайгаа болон сонирхолын бүлгийн төлөөлөлтэй хуваалцах, бусдаас сурах, бусдыг сургах, эргэцүүлэн ярилцах замаар дараагийн асуулт, үйлийг тодруулан үйлийг баримжаалах, гүйцэлдүүлэх, ажиглах, шинжлэх, эргэцүүлэх, дараагийн санаа төрөх гэсэн бүрдүүлбэр бүхий ажиллагааг БАГШ нэг бүр бүтээлчээр тасралтгүй байдлаар өөр өөрийн сурах ба сургах ажил хэрэгтээ нэвтрүүлэх чухал асуудлыг энэхүү судалгааны ажлын хүрээнд дэвшүүлж байна.

Ном зүй

- Б.Жадамбаа. (2018). Үйлийн судалгааг Монгол соёлын гени судлал болох нь .Лавай. 2018/18.х-9
- Б.Жадамбаа. (2010). Суралцаж хүншихүй талаарх бодгаль ертөнцийн хандлага, Монгол судлалын чуулган, №8 /43/ Улаанбаатар
- Б.Жадамбаа. (2010). Үйлийн явцдаа суралцаж хүншихүй, №8 /43/ Улаанбаатар
- Б.Жадамбаа, Б.Сандагдорж, Б.Тунгалаг, Л.Эрдэнэчимэг. (2015). Тогтвортой хөгжлийн боловсролын онол аргазүйн зарим асуудал. Улаанбаатар
- Б.Жадамбаа. (2016). Үйлийн судалгааны квант онол, Улаанбаатар
- Б.Жадамбаа. Ц.Чимэдлхам (2011). Судалгааны аргазүй. Улаанбаатар
- Буянжаргал. Л. (2015). Багш ажлын байрандаа хөгжихөд хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх арга зам. Лавай сэтгүүл. Улаанбаатар
- Odgerel D, Byambatogtokh G, Oyuntsetseg B, Tamir Ts, (2017). Current evaluation of student teacher learning action research. A regional workshop of the global assembly for know-edge democracy, Ulaanbaatar
- Н.Оюунбат, (2017). ЕБС-ийн багш нар үйлийн судалгааг хэрэглэж буй байдал, түүнийг дэлгэрүүлэх боломжийг судалсан нь. Улаанбаатар, /магистрын ажил/
- Е Mills.G. (2007). Action research. USA. Pearson
- Enkhmaa A, Maker Education. (2017). A regional workshop of the global assembly for know-edge democracy, Ulaanbaatar
- Б.Энхтүвшин. Монгол улсын хөгжлийн шинжлэх ухаанд суурилсан номлол

Learning through the action and the development opportunity at work place

*Wusihala
Inner Mongolia Normal University*

Abstract

This article is based on the latest theories and concepts of educational research, and the question of whether study of teachers' daily activities by the methodology of action research is effective. During the development of modern information and communication technologies, it is very important to organize training for teachers how they can develop at their work place using action research methodology based on the theory of teaching and learning, taking into account personal peculiarities and human values.

'Research' is defined as the process of creating new knowledge, spreading and sharing understanding among people, so this is seen how it is important for the result of learning and teacher development.

Teachers' knowledge and skills are key to improving the quality of learning, so the goal of this work is to determine the opportunities how teachers can improve educational service quality effectively on their work place exploring while teaching and teaching while exploring, in which they find problems in everyday life and solve them applying action research method.

Keywords

action research, teacher development, development at work place, teaching and learning.